



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/151

Төсөнбулаг

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 03 сарын 29-ны өдрийн 109 дүгээр "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын (хуучнаар) төрийн үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа 8208005821 нэгж талбарын дугаартай 1816 м<sup>2</sup> газрын эрхийг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс (9015396)-т шилжүүлж, байршлыг хавсралтаар баталж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн байгууллагын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/495 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 2 дугаарт бичигдсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР


**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС ( 9015396 ) - ИЙН  
ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Нэгж талбарын дугаар: 8208003821  
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг

Аймгийн Засаг даргын  
2024 оны 02 дугаар сарын 16 ны өдрийн  
... дугаар захирамжийн 157-р хавсралт



Огноо: 2024-01-12



Хэвцэний координат.

Дугаар	X	Y	Урт	Цэвүүд
1	5138736.257	288350.940	44.02	1-2
2	5138748.903	288308.988	40.78	2-3
3	5138788.745	288321.416	33.81	3-4
4	5138779.297	288353.981	0.89	4-5
5	5138778.844	288354.881	0.16	5-6
6	5138778.798	288355.013	8.60	6-7
7	5138778.250	288363.224	0.00	7-8
8	5138778.250	288363.224	41.87	8-1

Талбайн хэмжээ: 1816.3 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметр 10 метр багтана)